



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ҮЕНЧ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/44/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Гэрээт аудитор: Н.Батжаргал Утас: 70432545</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### **Товчилсон үгийн жагсаалт**

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗД</i>	<i>Засаг дарга</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>

**Агуулга**

0

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	төгрөгөөр .....5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	төгрөгөөр .....6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	төгрөгөөр .....7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	8
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	төгрөгөөр .....9
2.6 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН НЭМЭЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	төгрөгөөр .... 10
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	10
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	14
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	14
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....	15

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14000 Цэцэггарав Бие, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2021.03.15 № 2/161  
тандай \_\_\_\_\_ -тм № \_\_\_\_\_ -т

ҮЕНЧ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Л.НЯМЖАРГАЛ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Үенч сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Үенч сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, бага, дунд боловсролын чанар, үр дүн, багшийн ёс зүй зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд цалингийн картад албан хаагчдаар гарын үсэг зурж баталгаажуулаагүй, цалинг шилжүүлэхдээ ажилчдын дансыг бичээгүй, цалингаас суутгах төлбөр тооцоог цэсэд оруулахгүйгээр банк руу шилжүүлсэн жагсаалтаас хасаж тооцсоныг нотлох боломжгүй, бараа материалын тооллого хийгээгүй, тайлант онд худалдан авсан боох материалыг нярав орлогод авч тайлан гаргаагүй, бараа материалын зарлагыг жилийн эцсээр нэг өдөр

021020684

программд бүртгэж зарлага гаргасан, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй, нийгмийн даатгалын шимтгэл илүү тооцон суутгасан, худалдан авалтуудыг И баримтаар бүрэн баталгаажуулаагүй, авлага өр төлбөрийг барагдуулан ажиллаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль зэрэг эрх зүйн акттай нийцэхгүй, "үнэн зөв байх", "хэмжилт", "бодитой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>47,762,264.00</u></b>	<b><u>47,748,108.85</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,173,681.00	3,345,240.85
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,464,381.00	1,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,709,300.00	2,335,300.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	9,940.85
3351	Байгууллагаас авах авлага	00.00	9,940.85
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	44,588,583.00	44,402,868.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	00.00	4,019,500.00
35130	Эм боох материал	00.00	4,019,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	44,588,583.00	40,383,368.00
35440	Түлш, шатах тослох материал	6,970,600.00	3,397,795.00
35460	Хүнсний материал	8,473,700.00	7,849,825.00
35470	Бусад хангамжийн материал	29,135,748.00	29,135,748.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,141,401,158.10</u></b>	<b><u>3,294,345,172.46</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,141,401,158.10	3,294,345,172.46
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,021,401,158.10	3,174,345,172.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,127,258,589.00	3,357,258,589.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-199,427,042.16	-306,003,948.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,300,000.00	33,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,300,000.00	-33,300,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	216,178,075.00	222,075,227.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-193,959,574.36	-201,365,824.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	146,952,097.42	175,092,806.42
39208	Хуримтлагдсан элэгдэл	-75,710,986.80	-84,646,116.92
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	00.00	8,000,000.00
39217	Ном	110,000.00	3,934,440.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	120,000,000.00	120,000,000.00
39301	Програм хангамж	1,130,000.00	1,130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,130,000.00	-1,130,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	120,000,000.00	120,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,189,163,422.10</u></b>	<b><u>3,342,093,281.31</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>12,552,101.00</u></b>	<b><u>206,041.45</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	12,552,101.00	206,041.45
<b>413</b>	<b>Өглөг</b>	12,552,101.00	206,041.45
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,552,101.00	206,041.45
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,176,611,321.10</u></b>	<b><u>3,341,887,239.86</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,176,611,321.10	3,341,887,239.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	541,754,600.42	541,754,600.42
51101	Өмч: - төрийн	541,754,600.42	541,754,600.42
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,597,705,243.85	1,762,981,162.61
51210	Өмнөх үеийн үр дүн	1,597,705,243.85	1,593,705,243.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	169,275,918.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,037,151,476.83	1,037,151,476.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,189,163,422.10</u></b>	<b><u>3,342,093,281.31</u></b>

**2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,131,872,586.68</b>	<b>1,517,182,801.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>43,206,286.68</b>	<b>267,071,501.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	43,206,286.68	267,071,501.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,206,286.68	267,071,501.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	600,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,206,286.68	266,471,501.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>56,771,400.00</b>	<b>51,974,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,031,894,900.00	1,198,137,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,709,300.00	626,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,709,300.00	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	126,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	53,062,100.00	51,348,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,062,100.00	51,348,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,223,177,377.52</b>	<b>1,347,906,882.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,223,177,377.52</b>	<b>1,347,906,882.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,190,148,077.52	1,292,910,474.31
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	822,871,123.00	951,146,294.67
210101	Үндсэн цалин	818,864,102.00	946,678,868.67
210102	Нэмэгдэл	2,112,707.00	3,630,879.00
210104	Урамшуулал	00.00	836,547.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	104,960,460.00	120,405,038.00
210201	Тэтгэврийн даатгал	104,960,460.00	120,405,038.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	50,575,700.00	51,618,905.00
210301	Гэрэл, цахилгаан	8,971,900.00	7,633,500.00
210302	Түлш, халаалт	41,033,800.00	43,832,405.00
210303	Цэвэр, бохир ус	570,000.00	153,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,892,770.00	6,637,800.00
210401	Бичиг хэрэг	619,200.00	562,200.00
210402	Тээвэр, шатахуун	6,705,600.00	3,416,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	599,400.00	726,100.00
210404	Ном, хэвлэл	102,640.00	12,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	272,330.00	271,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,593,600.00	1,623,900.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	26,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	63,370,200.00	37,162,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	426,400.00	2,927,400.00
210502	Хоол, хүнс	60,788,600.00	32,625,115.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,155,200.00	1,609,535.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,021,700.00	648,000.00
210604	Урсгал засвар	2,021,700.00	648,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	401,300.00	109,500.00
210702	Дотоод албан томилолт	401,300.00	109,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	286,700.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	286,700.00	392,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	135,768,124.52	124,790,886.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,620,295.00	545,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,193,500.00	5,327,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,954,329.52	118,918,286.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	33,029,300.00	54,996,407.93
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,320,000.00	18,779,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,320,000.00	18,779,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,709,300.00	36,217,007.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,709,300.00	36,217,007.93
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-91,304,790.84</u></b>	<b><u>169,275,918.76</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-91,304,790.84</u></b>	<b><u>169,275,918.76</u></b>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,088,666,300.00</u></b>	<b><u>1,252,420,600.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>600,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	600,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	600,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,031,894,900.00	1,198,137,300.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	00.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,709,300.00	626,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,709,300.00	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	126,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	53,062,100.00	53,057,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,062,100.00	51,348,000.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	00.00	1,709,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,088,666,300.00</u></b>	<b><u>1,252,420,600.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>1,088,666,300.00</u></b>	<b><u>1,252,420,600.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>1,055,637,000.00</u></b>	<b><u>1,195,088,892.07</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	816,293,700.00	954,529,252.07
210101	Үндсэн цалин	570,303,500.00	705,123,778.18
210102	Нэмэгдэл	162,619,200.00	194,146,989.34
210104	Урамшуулал	57,841,500.00	55,258,484.55
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	101,436,600.00	128,913,700.00
210201	Тэтгэврийн даатгал	101,436,600.00	90,631,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	9,570,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	8,128,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,441,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	19,141,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,649,700.00	48,463,100.00
210301	Гэрэл, цахилгаан	8,971,900.00	7,633,500.00
210302	Түлш, халаалт	42,107,800.00	40,259,600.00
210303	Цэвэр, бохир ус	570,000.00	570,000.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,510,000.00	6,842,100.00
210401	Бичиг хэрэг	619,200.00	562,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,705,600.00	3,416,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	743,100.00	726,100.00
210404	Ном, хэвлэл	550,400.00	392,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	298,100.00	271,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,593,600.00	1,474,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	62,131,400.00	49,464,440.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	426,400.00	7,063,400.00
210502	Хоол, хүнс	59,550,300.00	32,699,240.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,154,700.00	9,701,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,736,400.00	650,000.00
210604	Урсгал засвар	1,736,400.00	650,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	401,300.00	109,500.00
210702	Дотоод албан томилолт	401,300.00	109,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	286,700.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	286,700.00	392,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,191,200.00	5,724,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,116,800.00	545,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,074,400.00	5,179,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,029,300.00</b>	<b>57,331,707.93</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,320,000.00	18,779,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,320,000.00	18,779,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,709,300.00	38,552,307.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,709,300.00	38,552,307.93
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	

#### 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,754,600.42	1,037,151,476.83	1,597,705,243.85	3,176,611,321.10
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,754,600.42	1,037,151,476.83	1,597,705,243.85	3,176,611,321.10
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,754,600.42	1,037,151,476.83	1,597,705,243.85	3,176,611,321.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-4,000,000.00	-4,000,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	541,754,600.42	1,037,151,476.83	1,593,705,243.85	3,172,611,321.10
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	169,275,918.76	169,275,918.76
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,754,600.42	1,037,151,476.83	1,762,981,162.61	3,341,887,239.86

**2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,254,065,400.00	1,213,868,292.07
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,254,065,400.00	1,213,868,292.07
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,225,850,400.00	1,195,088,892.07
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	957,065,000.00	954,529,252.07
210101	Үндсэн цалин	665,972,800.00	705,123,778.18
210102	Нэмэгдэл	221,165,100.00	194,146,989.34
210104	Урамшуулал	69,927,100.00	55,258,484.55
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	129,203,700.00	128,913,700.00
210201	Тэтгэврийн даатгал	90,921,200.00	90,631,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,570,500.00	9,570,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,656,500.00	8,128,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,914,200.00	1,441,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,141,300.00	19,141,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,348,000.00	48,463,100.00
210301	Гэрэл, цахилгаан	9,869,100.00	7,633,500.00
210302	Түлш, халаалт	40,908,900.00	40,259,600.00
210303	Цэвэр, бохир ус	570,000.00	570,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,204,300.00	6,842,100.00
210401	Бичиг хэрэг	619,200.00	562,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,416,900.00	3,416,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	726,100.00	726,100.00
210404	Ном, хэвлэл	550,400.00	392,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	298,100.00	271,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,593,600.00	1,474,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	72,862,600.00	49,464,440.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,063,400.00	7,063,400.00
210502	Хоол, хүнс	55,696,000.00	32,699,240.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,103,200.00	9,701,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,412,400.00	650,000.00
210604	Урсгал засвар	1,412,400.00	650,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	401,300.00	109,500.00
210702	Дотоод албан томилолт	401,300.00	109,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	392,000.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000.00	392,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	596,100.00	572,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	545,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,361,100.00	5,179,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	282,150,000.00	187,794,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,215,000.00	18,779,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,215,000.00	18,779,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,254,065,400.00	1,213,868,292.07
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,200,705,000.00	1,161,920,292.07
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,200,705,000.00	1,161,920,292.07
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	52,760,400.00	51,348,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	52,760,400.00	51,348,000.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	600,000.00	600,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	600,000.00

## 2.6 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН НЭМЭЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2335.3 мянган төгрөг төвлөрч, зарлага гаралгүй холбогдох төсөвт төвлөрүүлсэн тул тайлан гаргаагүй байна.

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. Ерөнхий зүйл

Үенч сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Л.Нямжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд нийгмийн даатгал, анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-наас 2021 оны 03 дугаар сарын 15 хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Н.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь Ковид -19 цар тахлаас хамааран хорио цээр тогтоосон, нягтлан бодогчийн ажлын хариуцлагаас хамааран хуулийн хугацаа хоцроож аудитад тайлангаа ирүүлсэн тул Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаа хоцорч тайланг аудитласан болно.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ховд аймгийн Үенч сумын сургууль нь “Сурлагын чанартаа ахиц гаргасан, эх хэлнийхээ чадварыг хөгжүүлсэн, ирээдүйн зорилготой, хариуцлагатай хүүхдийг төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлжээ. Энэхүү эрхэм зорилгын хүрээнд сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг сурагч бүрийн онцлогт нийцсэн чанартай сургалтыг зохион байгуулах замаар бие даан амьдрах чадвартай иргэнийг төлөвшүүлж ажиллах зорилго зорилтоо тодорхойлон ажиллажээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Үенч сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗД-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар батлагдсан хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар олгосон, цагийн бүртгэлээс илүү тооцон бодсон, хүүхдийн ирцийн бүртгэлийг илүү тооцон үргүй зардалд тусгасан нийт 2783.2 мянган төгрөгийн актийн төлбөр тавигдсанаас холбогдох этгээдээс 1148.3 мянган төгрөгийг төлүүлсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 1244002.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 12440.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 1347906.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 13479.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үенч сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 152929.6 мянган төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	3173.7	3345.2	171.6	5%
Бараа материал	44588.6	44402.8	-185.7	-0.01%
Үндсэн хөрөнгө	3141401.1	3294345.1	152944.0	5%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3189163.4</b>	<b>3342093.2</b>	<b>152929.8</b>	<b>5%</b>
<b>Өр төлбөр</b>	<b>12552.1</b>	<b>206.4</b>	<b>12346.1</b>	<b>-98%</b>
Цэвэр хөрөнгө, өмч	3176611.3	3341887.2	165275.9	5%
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3189163.4</b>	<b>3342093.2</b>	<b>152929.8</b>	<b>5%</b>

Авлага данс оны эцсийн үлдэгдэл 3345.2 мянган төгрөг болж 171.6 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын байгууллагаас авлагыг 964.3 мянган төгрөгийг барагдуулсан, нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн 2335.3 мянган төгрөгийг төсвөөс авах авлагаар бүртгэсэнтэй зэрэгтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 44402.8 мянган төгрөг болж 185.7 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд түлш болон хүнсний материалын нөөц буурсан болон эм боох материалыг нэмж нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 3141401.1 мянган төгрөг, оны эцэст 3294345.1 мянган төгрөг болж 152944.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ өсөлт нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн барилгын их засвар 230000.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сургуулийн хашаа 30000.0 мянган төгрөг, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж 28471.1 мянган төгрөгийн, төгсөгчдийн хандиваар 8000.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, урсгал зардлаас 9390.8 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох тогтоол шийдвэрийн дагуу бүртгэн авсан болон тайлант үеийн элэгдлийн зардал 118918.3 мянган төгрөг бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант үед үр дүнгийн тайланд нийт 1517182.8 мянган төгрөгийн орлого, нийт 1347906.8 мянган төгрөгийн зардал тайлагнасан нь хуримтлагдсан үр дүн дансыг 169275.9 мянган төгрөгөөр өсгөсөн байна. Өмнөх үеийн хөрөнгийн элэгдлийн зардал 4000.0 мянган төгрөгийг өмнөх үеийн үр дүнрүү залруулсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 385310.2 мянган төгрөгөөр буюу 34 хувиар өссөн байна. Энэ үзүүлэлт нь 166242.4 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэн болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 223865.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 124729.5 мянган төгрөгөөр буюу 10 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 143719.7 мянган төгрөг буюу 18 хувь, тогтмол зардал 1043.2 мянган төгрөг буюу 2 хувиар тус тус өссөн болон бусад зардлууд буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 2018, 2019 онд хөрөнгийн элэгдлийн зардал дутуу тооцогдсон 4000.0 мянган төгрөгийг хаасан бичилт хийсэн байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1265452.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1265452.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сард сургуулийн 2020 оны төсвийг 1265452.7 мянган төгрөгөөр баталжээ. 2020 оны 09-р сард ИТХ-аар төсөвт тодотгол 1254065.4 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон.

#### **Төсвийн гүйцэтгэл:**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1254065.4 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 52760.4 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1200705.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 600.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1198137.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 51348.0 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагаанаас 600.0 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 1250085.3 мянган төгрөгийг төвлөрүүлэн, урсгал үйл ажиллагаанд 1213868.3 мянган төгрөгийг зарцуулж 36217.0 мянган төгрөгийг холбогдох төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1213868.3 мянган төгрөг буюу 97.0 хувьтай байна. зардлын ангиллаар авч төсвөөс хэтэрсэн зардал байхгүй байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээ 19676.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой хүүхдийн сургууль танхимаар ажиллаагүй, бараа материалын нөөц ихтэй байсан зэрэгтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2489.8
81806	Хүүхдийн хоол	26571.0
81827	Үдийн цай	6867.9
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	268.2
80109	Бичиг үсгийн боловсрол	20.1
	<b>ДҮН</b>	<b>36217.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төсвөөс авлага 1709.3 мянган төгрөг, аймгийн боловсрол, соёл урлагийн газраас нэмэлт санхүүжилт 500.0 мянган төгрөг, түрээсийн номын төлбөр 126.0 мянган төгрөг нийт 2335.3 мянган төгрөг төвлөрч гүйлгээ хийлгүйгээр холбогдох төсөвт төвлөрсөн бөгөөд санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн байна.

#### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс хугацаандаа оруулсан 90, хугацаа хоцроосон 48, огт мэдээлээгүй 4 мэдээлэл байна. Дараа жилийн төсвийн төсөл, Санхүүгийн тайлан, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг огт мэдээлээгүй байна.

#### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 420.0 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт, 12251.1 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага, 16735.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөгдөж акт, албан шаардлага болон 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,059,453.00 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 56103.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1001526.9 мянган төгрөгийн албан шаардлага, 1822.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа:** Аудитын явцад үндсэн хөрөнгийн ангилал, элэгдлийн тооцоолол, нэмэлт дансны орлоготой холбоотой 56103.3 мянган төгрөгийн залруулга хийгдсэн болно.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил:** Аудитаар төлбөрийн 1 акт тогтоож, 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Хувь хүнээр төлүүлэхээр тогтоосон төлбөрийн актыг байгууллагаас төлсөн 774.2 мянган төгрөг, Нүүрсний зарцуулалт болон хоол хүнсний материалын орлого дутуу авсан 1048.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Цалингийн картад албан хаагчдаар гарын үсэг зурж баталгаажуулаагүй, цалинг шилжүүлэхдээ ажилчдын дансыг бичээгүй, цалингаас суутгах төлбөр тооцоог цэсэд оруулахгүйгээр банк руу шилжүүлсэн жагсаалтаас хасаж тооцсоныг нотлох боломжгүй 950177.2 мянган төгрөг, Бараа материал бүртгэлд байгаа 44402.8 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, тайлант онд худалдан авсан 6946.9 мянган төгрөгийн эм боох материалыг нярав орлогод авч тайлан гаргаагүй, бараа материалын зарлагыг жилийн эцсээр нэг өдөр программд бүртгэж зарлага гаргасан нийт 1001526.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах талаар албан шаардлага бичих

3. Тайлант хугацааны шилэн дансны мэдээллээс хугацаа хоцроосон 48, огт мэдээлээгүй 4 мэдээлэл байна. Дараа жилийн төсвийн төсөл, Санхүүгийн тайлан, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг огт мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах талаар албан шаардлага бичих

**Аудитын зөвлөмж:** Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар төвлөрсөн дулаан халаалтын гэрээ, түүний зардлын талаар авч үзэх нь зүйтэй байна.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд шатахууны худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.
- 1.2. Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн

баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

**2.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Тайлант хугацааны цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэл нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хянаж үзэхэд тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн шимтгэл илүү суутгасан байна.

2.2. Эрсдэл: Хуулийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-д “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж зөрүүг тодорхой болгон тооцож залруулах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

Огноо:	Аудитын нэр:	Үенч сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/44/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Үенч сумын ЕБС		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, бараа материалын тооллого хийгээгүй, нярав эм боох	1001526.9	Албан шаардлага		

	материалын тайлан гаргаагүй, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй			Захирал, Нягтлан бодогч	Л.Нямжаргал О.Мягмар
2	Бараа материалын зарцуулалт илүү болон орлого дутуу авсан	1822.2	Төлбөрийн акт		
3	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй	0	Албан шаардлага		
4	Нийгмийн даатгалын шимтгэл илүү тооцон суутгасан	0	Зөвлөмж		
5.	Худалдан авалтуудыг И баримтаар баталгаажуулаагүй	0	Зөвлөмж		
<b>ДҮН</b>		<b>1003349.1</b>			

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**